

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

20~~25~~²⁵ оны 06 сарын 30-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

*Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэхийг зөвшөөрөх тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь хэсэг, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Сэндли ББСБ” ХК-ийн өөрийн хөрөнгийг хугацааны эцэст хувьцаанд хөрвөх нөхцөл бүхий хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү шийдвэрийн 1-д дурдсан хоёрдогч өглөг татан төвлөрүүлэх нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэхээр тогтсугай.

3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан хоёрдогч өглөгийг хугацааны эцэст компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх зорилгоор нэг бүр нь 50 (тавь) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 67,000,000 (жаран долоон сая) ширхэг энгийн хувьцааг нэмж зарласугай.

4. Энэхүү тогтоолын 3-д дурдсан зарласан боловч эргэлтэнд гаргаагүй 67,000,000 (жаран долоон сая) энгийн ширхэг хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй болохыг дурдсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

20~~25~~ оны 06 сарын 30-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5.1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Дүрмийн 4.2-т заасан “Компани нэг бүр нь 50 /тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 223,570,000 /хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга/ ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 11,178,500,000 /арван тэрбум нэг зуун далан найман сая таван зуун мянга/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна” гэснийг
 - 4.2. “Компани нэг бүр нь 50 /тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 290,570,000 /хоёр зуун ерэн сая таван зуун далан мянга/ ширхэг энгийн хувьцаатай байна.
 - 4.3. Компани нь нэг бүр нь 50 /тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 223,570,000 ширхэг энгийн хувьцааг эргэлтэнд гаргасан буюу нийт 11,178,500,000 /арван тэрбум нэг зуун далан найман сая таван зуун мянга/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.
 - 4.4. Компани нь нэг бүр нь 50 /тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 67,000,000 /жаран долоон сая/ ширхэг зарласан боловч гаргаагүй хувьцаатай байна.” гэж өөрчлөх.
2. Энэхүү шийдвэрийн 1.1-т заасан дүрмийн өөрчлөлттэй холбоотой Компанийн дүрмийн 4.3-ыг 4.5; 4.4-ийг 4.6; 4.5-ыг 4.7 болгон тус тус дугаарлалтыг өөрчилсүгэй.
3. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

